



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 26

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,
сэлбэг хэрэгслээр худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3 дах заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 10,000,000 (Арван сая) төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 20-66 ДУЭ улсын дугаартай Nissan murino автомашиныг сэлбэг хэрэгслээр худалдах үнийг хавсралтад заасны дагуу тогтоон худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.МӨНХЧУЛУУН



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
26 дугаар тогтоолын хавсралт

Худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлд вэрл эсэн он	Ашигл алтад орсон он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдс ан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Адаацаг сумын ЗДТГ	NISSAN, Murano	ДУЭ	2066	2004	2016	10,000,000	10,000,000	0.00	300,000
Нийт							10,000,000 (арван сая) төгрөг	10,000,000 (арван сая) төгрөг	-	300,000 (гурван зуун мянга) төгрөг